



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД  
ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС  
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2026 он**

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ДАГУУ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагаатай холбоотой иргэний гаргасан гомдлын дагуу дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд холбогдох санхүүгийн баримт материал цуглуулан, дүн шинжилгээ хийн, дүгнэлт гаргах зорилгоор дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

### ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

1. Б.Сумъяа гомдолдоо *“Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/229 дүгээр тушаалаар БНСУ-д 2025 оны 08 дугаар сарын сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 30-ний өдрүүдэд хамтарсан бэлтгэлд оруулах зорилгоор зам хоног, хоол, бусад холбогдох зардлуудыг тооцон авсан боловч шигшээ багийн тамирчин Б.Гэрэлтуяаг 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улс руу буцаасан мөн тэрээр БНСУ-д тус зардлын тушаалд хавсаргасан түрээсийн байранд бус солонгос дасгалжуулагчийн гэрт, хажуу өрөөнд амьдарч байсан”* -гэснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж шалгалаа.
  - 1.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн БНСУ-ын Сөүл хотод 2025 оны 08 дугаар сарын 03-аас 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд хамтарсан бэлтгэлд оролцох тэшүүрийн тамирчин Э.Мөнх-Эрдэнэ, М.Гэрэлтуяа, дасгалжуулагч Б.Бат-Оргил нарын зардлыг 72,207.3 мянган төгрөгөөр баталж, зардлыг холбооны дансанд 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр 24,699.0 мянган төгрөг, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр 47,508.3 мянган төгрөгийг шилжүүлж бүрэн санхүүжүүлсэн байна.
  - 1.2 Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн холбооноос БНСУ-д хамтарсан бэлтгэл хийсэн санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг санхүүгийн анхан шатны баримтаар БТСУХ-нд 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр тайлагнасан.
  - 1.3 Шигшээ багийн тамирчид буудалд байрлаагүй байшин түрээсэлсэн тул бэлтгэлээс 20 хоногийн өмнө буцсан тамирчин Б.Гэрэлтуяагийн байрны зардалд хэмнэлт үүсгээгүй гэсэн тайлбарыг холбооноос мэдүүлсэн.
  - 1.4 Монголын Тэшүүрийн холбооны фэйсбүүк хуудсанд тавьсан тайлбарт *“... тамирчин Б.Гэрэлтуяа Өвлийн Олимпын Наадмын эрх авах зорилгоор Германд зохиогдох тэмцээнүүдэд оролцохын тулд зайлшгүй Монголд ирж Шенгений виз мэдүүлэх шаардлагатай болсон тул 9 дүгээр сарын 11-ний өдөр Монголд буцаж ирсэн”* тухай нийтлэл бичсэн байна.
  - 1.5 БТСУХ-ны санхүүгийн хэлтсээс санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланд дотоод хяналтыг хэрэгжүүлэн хамтарсан бэлтгэлээс буцсан тамирчин Б.Гэрэлтуяагаас 20 хоногийн зардал 11,299.8 мянган төгрөг, дасгалжуулагч Б.Бат-Оргилоос

согтууруулах ундааны болон хоолны бус бусад зардал гаргасан тооцоог хянаж 1,470.1 мянган төгрөгийг буцаах тооцоо нийлсэн акт үйлдэж, БТСУХ-ны төрийн сангийн 100900034033 дугаар дансанд Тэшүүрийн холбооноос 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 11,299.8 мянган төгрөгийг, дасгалжуулагч Б.Бат-Оргил 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 1,470.1 мянган төгрөгийг буцаан төлсөн байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хүний тоо	Хоног	Нэгж үнэ	Нийт баталсан зардал	Гүйцэтгэл	Зөрүү буюу буцаасан дүн
Замын зардал	1	-	1,672.5	1,672.5	1,672.5	-
	2	-	1,609.8	3,219.5	3,219.5	-
Байр			6,885 ам доллар	24,699.0	24,699.0	-
Хоол	3	59	50.0 мянган вон	22,921.5	10,150.8	12,770.7
Дотоод тээвэр, зал, мөсний төлбөр	1	6	5,490 ам доллар	19,694.7	19,694.7	-
Нийт дүн				72,207.3	59,436.5	12,770.7

1.6 Тамирчид, дасгалжуулагчийн хоолны санхүүгийн баримтад согтууруулах ундаа, хоолны бус барааны төлбөрт 1,470.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 29.2.Төрийн ёслол, хүндэтгэлийн гадаад арга хэмжээг зохион байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Б.Сумъяа гомдолдоо “Монгол Улсаас Шорт трекийн дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд тамирчин Б.Гэрэлтуяа оролцох болзол хангаагүй байхад Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/292 дугаар тушаалаар санхүүжилт авсан, 2025 оны 10 дугаар сарын 06-аас 20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан дэлхийн цомын тэмцээнд тамирчин Э.Мөнх-Эрдэнэ ганцаараа оролцсон” гэсэн гомдлыг хянан шалгалаа.

2.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/292 дугаар тушаалаар Канад улсын Монреал хотод 2025 оны 10 дугаар сарын 06-аас 20-ны өдрүүдэд Дэлхийн цомын тэмцээнд оролцох Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн тамирчин Э.Мөнх-Эрдэнэ, М.Гэрэлтуяа, дасгалжуулагч Б.Бат-Оргил нарын зардлыг 45,539.3 мянган төгрөгөөр баталж, зардлыг холбооны дансанд 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 45,539.3 мянган төгрөгийг бүрэн шилжүүлж санхүүжүүлсэн байна.

2.2 БТСУХ, Монголын Тэшүүрийн холбооны хооронд 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Үндэсний шигшээ багийг “Милан Кортина-2026” өвлийн олимпын наадамд бэлтгэн оролцуулахад улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг

үзүүлэх” 43 дугаар гэрээний 4.4.27. ... гэрээний дагуу олгосон санхүүжилт, түүний гүйцэтгэлийн тайланг тухайн арга хэмжээг дууссанаас хойш 14 хоногт багтаан хүлээлгэн өгөхөөр заасан байна. Монголын тэшүүрийн холбооноос гэрээ болон удирдамжид заасан хугацаанд буюу тэмцээн дууссанаас хойш 3 хоногийн дотор оролцсон дүн, илтгэх хуудас, санхүүгийн тооцоо тайланг гаргах өгөх үүргээ биелүүлээгүй байна.

- 2.3 БТСУХ-ны санхүүгийн хэлтсээс мөнгөн урьдчилгааны тайланг хянаж Дэлхийн цомын тэмцээнд яваагүй тамирчин Б.Гэрэлтуяа, дасгалжуулагч Б.Бат-Оргил нарын зардлыг тооцон 29,041.3 мянган төгрөгийг буцаахаар шийдвэрлэн, Тэшүүрийн холбооноос 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр БТСУХ-ны төрийн сангийн 100900034033 дугаар дансанд буцаан төлсөн байна.
- 2.4 Дэлхийн цомын тэмцээнд яваагүй тамирчин, дасгалжуулагч нарын зардлыг дотоод хяналт шалгалтаар дахин нягтлан шалгахад 29,292.3 мянган төгрөгийн зардлыг буцаан төлөхөөр тооцоо гарч Тэшүүрийн холбооноос төлсөн дүнтэй тулгахад 251.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хүний тоо	Нэгж үнэ	Нийт баталсан зардал	Гүйцэтгэл	Зөрүү буюу буцаах дүн
Замын зардал	3	4,930.7	14,792.1	4,930.7	9,861.4
Байр	-	7,086.3 канад доллар	18,446.2	6,148.7	12,297.5
Хоол	-	4,110.57 канад доллар	10,700.1	3,566.7	7,133.4
Мөсний төлбөр	-	60 канад доллар	156.2	156.2	(0.0)
Визний хураамж	3	185 канад доллар	1,444.7	1,444.7	
Нийт дүн			45,539.3	14,802.3	29,292.3

3. Б.Сумъяа гомдолдоо “БТСУХ-ны даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/326 дугаар тушаалын дагуу Казакстан Улсад зохион байгуулагдсан залуучуудын дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд тамирчин М.Борхүү ганцаараа оролцож, Монголын тэшүүрийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Нарангэрэлийн төрсөн охин А.Биндэръяа багийн ахлагч статусаар дагалдан явсан болно. Дээрх хоёр тэмцээнд дасгалжуулагч багш тус улсад зорчих эрхийн виз гараагүй улмаас оролцоогүй гэдэг тайлбарыг холбоо өгсөн” гэсэн гомдлыг хянан шалгалаа.

- 3.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/326 дугаар тушаалаар Казакстан улсын Астана хотод 2025 оны дүгээр сарын 03-аас 16-ны өдрүүдэд Дэлхийн залуучуудын цомын аварга шалгаруулах тэмцээнд оролцох Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн тамирчин М.Борхүү, дасгалжуулагч Б.Бат-Оргил нарын зардлыг 20,461.4 мянган төгрөгөөр баталж, зардлыг холбооны дансанд 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 20,461.4 мянган төгрөгийг бүрэн шилжүүлж санхүүжүүлсэн байна.
- 3.2 Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн холбооноос Казакстан улсын Астана хотод болсон Дэлхийн залуучуудын цомын аварга шалгаруулах тэмцээний санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг санхүүгийн анхан шатны баримтаар БТСУХ-нд 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр тайлагнасан.

3.3 Монголын Тэшүүрийн холбооны фэйсбүүк хуудсанд тавьсан тайлбарт "... Дэлхийн Залуучуудын Шорт трекийн цомын аварга шалгаруулах тэмцээнд шигшээ багийн тамирчин М.Борхүү оролцсон. Дасгалжуулагчаар Б.Бат-Оргил явахаар бүртгүүлсэн байсан боловч 2025 оны 11 дүгээр сард Польш, Нидерланд улсуудад зохион байгуулах Дэлхийн цуврал тэмцээнүүдэд оролцохоор Сөүл хотод байрлах Польшийн элчин сайдын яамны Консулын газарт виз мэдүүлсэн тул оролцох боломжгүй болсон. Олон улсын тэшүүрийн холбооноос багийн ахлагчийг Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай хүн байхыг шаарддаг тул А.Биндэръяаг хичээлээс нь чөлөө авхуулан явуулсан" тухай мэдээлэл нийтэлжээ.

3.4 БТСУХ-ны санхүүгийн хэлтсээс Тэшүүрийн холбооны ирүүлсэн гүйцэтгэлийн тайланд дотоод хяналтыг хэрэгжүүлэн уг тэмцээнд яваагүй дасгалжуулагч Б.Бат-Оргилын зардлыг тооцон 8,002.6 мянган төгрөгийг буцаах тооцоо нийлсэн актыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр үйлдэж 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тус холбооноос авах авлагын үлдэгдлээр тайлагнаж баталгаажуулсан байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хүний тоо	Хоног	Нэгж үнэ	Нийт баталсан зардал	Гүйцэтгэл	Зөрүү буюу буцаасан дүн
Замын зардал	2		2,450.3	4,900.6	3,510.4	1,390.2
Дотоод тээвэр	2	4	10 ам доллар	143.7	71.9	71.9
Байр хоол	2	14	150 ам доллар	15,093.6	8,553.1	6,540.6
Мөсний төлбөр	1	6	15 ам доллар	323.4	323.4	-
Нийт дүн				20,461.4	12,458.8	8,002.6

4. Б.Сумъяа гомдолдоо "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан "Шалгуур үзүүлэлт, ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай" журмын хавсралтад заасан Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийн 2 дугаар зүйлийн 2.1.2, 2.1.3, 2.1.4 дэх хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийг Монголын тэшүүрийн холбоо хангахгүй байгаа гэж үзэж байна" гэсэн гомдлыг хянан шалгалаа.

4.1 Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт" -ийн 2.1.2, 2.1.3, 2.1.4 дэх заалтуудыг Монголын тэшүүрийн холбоо хангасан эсэхийг дараах хүснэгтэд үнэллээ.

№	Шалгуур үзүүлэлт	Бодит нөхцөл байдал	Үнэлгээ
1	2.1.2. Спортын төрлөөр олимп, паралимпын наадам, тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн аварга шалгаруулах тэмцээнд сүүлийн 3 жил медальт болон шагналт байрт шалгарсан байх;	Монголын Тэшүүрийн холбооноос Үндэсний шигшээ багийг байгуулах 2025 оны сонгон шалгаруулалтад баримт материал ирүүлээгүй байна. Тус холбооны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 14 дугаар албан	Хангахгүй

		бичгээр ирүүлсэн 3 жилийн өмнөх материалыг үндэслэж гэрээ байгуулсан гэсэн тайлбарыг БТСУХ-ноос өгсөн.	
2	2.1.3. Спортын холбооны төсвийн зарцуулалт шилэн байх;	Шилэн дансны цахим хуудас, байгууллагын веб хуудсанд нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангасан төсөв санхүүгийн мэдээллийг байршуулаагүй	Хангахгүй
3	2.1.4. Тухайн спортын холбоо нь Ажлын албатай байх;	Монголын Тэшүүрийн холбооны ажлын алба байгуулсан удирдах зөвлөлийн шийдвэр, ажлын албаны орон тоо, бүтцийн мэдээлэл байхгүй	Хангахгүй

4.2 Монголын Тэшүүрийн холбооноос Үндэсний шигшээ багийг байгуулах 2025 оны сонгон шалгаруулалтад баримт материал ирүүлээгүй байхад өмнө ирүүлсэн мэдээллийг үндэслэн шигшээ багийг байгуулсан, холбооны дэргэд ажлын алба байгуулагдаагүй зэрэг ССАЖЗ-ын сайдын 2025 оны А/23 дугаар тушаалаар баталсан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг хангахгүй зөрчил илэрлээ.

5. Б.Сумъяа гомдолдоо “Монголын тэшүүрийн холбоо 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн нийгмийн сүлжээн дэх цахим хаягтаа оруулсан мэдэгдэлд хүний нөөцийн асуудлын талаар дурдсан, төсвийн зарцуулалт шилэн биш байна” гэсэн гомдлыг хянан шалгалаа.

5.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/60 дугаар тушаалаар Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнийг баталсан. Тушаалын хоёрдугаар заалтаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллахыг Монголын Тэшүүрийн холбоонд үүрэг болгосон байна.

5.2 Монголын Тэшүүрийн холбооны цахим хуудас /sport.gov.mn/skating// -нд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангасан мэдээллийн цэс байхгүй, хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг өөрийн цахим хуудсанд мэдээлээгүй байна.



## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



ОУХМ А. Зулдаа баяр хүргэж спортын өндөр амжилт хүсье.

Тэшүүрийн холбоо © 2021-05-01



О.Мерлендээ баяр хүргэж спортын өндөр амжилт хүсье.

Тэшүүрийн холбоо © 2021-05-01



Г.Энхзул, З.Мөнх-Эрдэнэ хоёртоо баяр хүргэж спортын амжилт хүсье.

Тэшүүрийн холбоо © 2021-05-01



А.Бүрэнбаяргаа баяр хүргэж спортын өндөр амжилт гаргахыг хүсье.

Тэшүүрийн холбоо © 2021-05-01

5.3 Шилэн дансны тухай хуулийн 6.9. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, ... санхүүжилт, ... төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн ... 3.1.5<sup>1</sup>-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр ... санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах... гэсэн заалтын хэрэгжилтийг шалгахад Монголын Тэшүүрийн холбоо нь 2025 онд улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн 12 удаагийн 404,282.9 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Монголын тэшүүрийн холбоо

И-мэйл: Ажлын утас: Шуудангийн хаяг: Сошиал хаяг: Дэлгэрэнгүй мэдээлэл Салбар байгууллагууд

Нэр томъёо

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант он: 2025

Нийт хандлагыг 21 Тэмдэглэгээний тайлбар

ААНБ, ТББ, Иргэн

Хөрөнгө оруулалт, тэндэр, худалдан авалт

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Зөвөл эсэх	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл	Улирал бүр	дараа сарын 15-ны дотор	*	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

5.4 Мөн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 5.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэ журмын 19 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

<sup>1</sup> Шилэн дансны тухай хуулийн 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

## ДҮГНЭЛТ

Дотоод хяналт шалгалтаар Монголын Тэшүүрийн холбоонд улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтын анхан шатны баримт, тайлан, тайлбарыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

1. БТСУХ-ны даргын 2025 оны А/229 дүгээр тушаалаар баталсан төсвийн дэмжлэгийн санхүүжилтээр БНСУ-ын Сөүл хотод хамтарсан бэлтгэлд гарсан тамирчин М.Гэрэлтуяа Германд болох тэмцээнд оролцох болсон тул 2025 оны 09 дүгээр сарын 11-нд эх орондоо буцаж ирсэн бөгөөд иргэн Б.Сумъяагийн цахим орчинд нийтэлсэн мэдээллийн үр дүнгээр БТСУХ-ны санхүүгийн хэлтсээс дотоод хяналт шалгалт хийж, 11,299.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлсэн байна.

Мөн уг хамтарсан бэлтгэлд оролцсон тамирчид, дасгалжуулагчийн хоолны санхүүгийн баримтад согтууруулах ундаа, хоолны бус барааны төлбөрт 1,470.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 29.2. *“Төрийн ёслол, хүндэтгэлийн гадаад арга хэмжээг зохион байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно”* гэсэн заалтыг зөрчсөн тул улсын төсөвт буцаан төлүүлсэн байна.

2. БТСУХ-ны даргын 2025 оны А/292 дугаар тушаалаар баталсан төсвийн дэмжлэгийн санхүүжилтээр Канад Улсын Монреал хотод болсон Дэлхийн цомын тэмцээнд тамирчин М.Гэрэлтуяа, дасгалжуулагч Б.Бат-Оргил нар оролцоогүй үнэн бөгөөд иргэн Б.Сумъяагийн цахим орчинд нийтэлсэн мэдээллийн үр дүнгээр БТСУХ-ны санхүүгийн хэлтсээс дотоод хяналт шалгалт хийж, 29,041.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлсэн байна.
3. БТСУХ-ны даргын 2025 оны А/326 дугаар тушаалаар баталсан төсвийн дэмжлэгийн санхүүжилтээр Казакстан Улсын Астана хотод болсон Дэлхийн Залуучуудын цомын аварга шалгаруулах тэмцээнд тамирчин М.Борхүү ганцаараа оролцсон нь бөгөөд иргэн Б.Сумъяагийн цахим орчинд нийтэлсэн мэдээллийн үр дүнгээр БТСУХ-ны санхүүгийн хэлтсээс дотоод хяналт шалгалт хийж, дасгалжуулагчаар оролцох байсан Б.Бат-Оргилын зардал болох 8,002.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлэхээр санхүүгийн тайланд авлага үүсгэсэн байна.
4. Монголын Тэшүүрийн холбооноос Үндэсний шигшээ багийг байгуулах 2025 оны сонгон шалгаруулалтад баримт материал ирүүлээгүй байхад өмнө ирүүлсэн мэдээллийг үндэслэн шигшээ багийг байгуулсан, холбооны дэргэд ажлын алба байгуулагдаагүй зэрэг ССАЖЗ-ын сайдын 2025 оны А/23 дугаар тушаалаар баталсан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг хангахгүй байхад Үндэсний шигшээ багийг байгуулсан байна.
5. Монголын Тэшүүрийн холбооны цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангасан мэдээллийн цэс байхгүй, хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг мэдээлээгүй, Шилэн

дансны тухай хуулийн 6.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүй буюу 2025 онд улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн 12 удаагийн 404,282.9 мянган төгрөгийн зарцуулалтын мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Монголын Тэшүүрийн холбоо нь Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/229, А/292, А/326 дугаар тушаалаар Олон улсын уралдаан тэмцээн, хамтарсан бэлтгэлд зориулан улсын төсвөөс 138.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг бүрэн авсан боловч шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчдыг төлөвлөсөн тэмцээнд бүрэлдэхүүн дутуу оролцуулж 49.8 сая төгрөгийг дутуу зарцуулсан, олгосон санхүүжилтийн зарцуулалтын тайланг гэрээнд заасан хугацаанд тайлагнаагүй, согтууруулах ундаа, зориулалт бус барааны төлбөрт 1,470.1 мянган төгрөг зарцуулсан, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв санхүүгийн ил тод мэдээллийг хангаж ажиллаагүй, Биеийн тамир, спортын Улсын хороо нь Үндэсний шигшээ багийг байгуулах сонгон шалгаруулалтад тус холбооноос баримт материал ирүүлээгүй байхад шигшээ багийг байгуулсан зэргээс үзэхэд дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

## **ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ**

Дотоод хяналт шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтэд даалгаж байна.

**Зөвлөмж 1.** Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт” -ийн 2.1, 2.2, 2.3 дахь заалтуудыг Монголын тэшүүрийн холбоо хангасан эсэхийг ажлын хэсгийн дүгнэлтээр гаргаж Үндэсний шигшээ багийг байгуулах;

**Зөвлөмж 2.** Үндэсний шигшээ багийн холбоонд олгож буй Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтын тайланг гэрээнд заасан хугацаанд авч, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Санхүүгийн хэлтсийн хяналтаар оруулж, тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллах;

**Зөвлөмж 3.** Үндэсний шигшээ багийн холбоодод олгосон Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв санхүүгийн ил тод мэдээллийг хангуулж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах;

1. Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**